

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2025/21-04-ШТА-НА

БУЛГАН АЙМАГ
2025

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер : Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2716 Цахим хаяг: tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгтийн товъёо

Дүрслэлийн товъёо

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

А бүлэг: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙГЭЭС ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А.1. Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр тооцох албан тушаалтнуудын хандлага, сэтгэлгээ дутмаг байна.

А.2. Сумын ЗДТГ-ууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн бусад арга хэмжээний хориглосон заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 20.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Б: ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН 21 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 1701.8 САЯ ТӨГРӨГИЙН АЖЛЫГ ЗУРАГ ТӨСӨВГҮЙ БАТАЛСАН БАЙНА.

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц, гэрээний хугацаа гүйцэтгэлийн чанарт анхаарах шаардлагатай байна.

Б.2. Цахим худалдан авах ажиллагааг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

В.1. Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналтаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч хуулийн хэрэгжилт, үр дүн нэмэгдэхгүй байна.

В.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хэмнэлт, үр дүн тооцоогүй, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын ажил хангалтгүй байна.

В.3. Орон нутгийн өмчит зарим байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Ирүүлсэн санал, тайлбар

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
АТҮТ	Автотээврийн үндэсний төв
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ

Хүснэгтийн товьёг

<i>Д/д</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 1	Төсөвт байгууллагуудын дугаар авсан байдал аймгийн дүнгээр	4
Хүснэгт 2	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд баталсан төсөл арга хэмжээний ангилал	8
Хүснэгт 3	Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ	10
Хүснэгт 4	Төрийн хэмнэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн хяналт	12
Хүснэгт 5	ТЕЗ-ийүүлийн 3 жилийн урсгал зардал	12
Хүснэгт 6	Төрийн хэмнэлтийн тухай хуульд тусгасан урсгал зардлуудын төлөвлөгөө гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Шилэн дансны мэдээлэл	14

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаал, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу? • Хөрөнгө оруулалттай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу? • Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймгийн ТЭЗ-ийн харьяаны аймаг, сумдын ЗДТГ, ИТХ, Захирагчийн алба, ойн анги болон орон нутгийн өмчит ААТҮГ зэрэг газруудыг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд: • Монгол Улсын 2022, 2023, 2024 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Төрийн албаны тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор П.Содном, аудитор Г.Цэрэнлхам нар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
--	--

А.ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙГЭЭС ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

А.1 Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр тооцох албан тушаалтнуудын хандлага, сэтгэлгээ дутмаг байна.

А.1.1. МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын дагуу “орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслийн ашиглалтын тухай” аймгийн Засаг даргын 2022 оны А/380 дугаар захирамжаар орон нутгийн өмчийн тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр бүхий улсын дугаар авах ажлыг хэрэгжүүлэх, автомашины ашиглалтад хяналт тавих зэрэг ажлыг зохион байгуулах талаар холбогдох албан тушаалтанд даалгасан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт 91 байгууллагын 207 тээврийн хэрэгсэл дугаарын дэвсгэр өнгө солигдсон, 54 тээврийн хэрэгсэл дугаар солигдоогүй, эвдэрч зам тээврийн хөдөлгөөнд оролцох боломжгүй 82 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

АТҮТ-ийн Булган салбарт бүртгэлтэй аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 235 тээврийн хэрэгслээс 142 дугаарын дэвсгэр өнгийг сольсон бол 93 нь энгийн дугаартай байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 40 хувь дэвсгэр өнгийн дугаар аваагүй байна.

Булган аймгийн нийт төсвийн байгууллагын 474 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс 292 тээврийн хэрэгслийн дугаарыг хөх дэвсгэртэй болгосон бол 182 тээврийн хэрэгсэл нь тод өнгийн дэвсгэр бүхий дугаарыг аваагүй, үүнд акталсан болон ашиглалтгүй авто дээврийн хэрэгсэл дийлэнх хувийг эзэлж байгаа гэсэн тайлбарыг өгч байгаа ч ОНӨГ-аас ирүүлсэн мэдээлэл зөрүүтэй байна.

Хүснэгт № 1 Төсөвт байгууллагуудын дугаар авсан байдал аймгийн дүнгээр

Байгууллага	Цэнхэр дугаар авсан	Цэнхэр дугаар аваагүй	Зөрчилтэй
ОНӨГ	207	54	82
АТҮТ Булган салбар	292	182	

Дээрх хүснэгтээс харахад АТҮТ-д бүртгэлтэй тээврийн хэрэгслийн бүртгэлийг тулгалт хийж, зөрүүг арилгах, улсын дугаарын дэвсгэр өнгийг солиулж хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

ЗГ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Орон нутгийн өмчийн газраас 14 байгууллагын 28 автомашиныг тухайн байгууллагын гражид лацдан битүүмжилж, 6 байгууллагад ажлын зориулалтаар 6 тээврийн хэрэгслийг хуваарилах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авсан ч хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн өмчийн автомашиныг нэгдсэн зохион байгуулалтад оруулах граж, хашаа зэрэг төвлөрүүлэн зохион байгуулах нөхцөл боломжгүйгээс орон нутагт бүрэн хэрэгжих боломжгүй байна.

Хуулийн үйлчлэх хүрээ, хязгаарлалтуудыг нэмэлт өөрчлөлтөөр тэлж байгаа нь хуулийн үйлчлэлийг сулруулж байна. Тухайлбал тус хуулийн 6 дугаар зүйлд 2 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр авто машин ашиглах байгууллагуудыг нэмсэн байна.

Төрийн аудитын газраас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар тээврийн хэрэгслийн хязгаарлалттай 10.6 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрсэн байна.

- Санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд хувийн авто машинаар явахдаа гэрээ байгуулаагүй 982.5 сая төгрөгийн шатахуун зарцуулсантай холбоотой албан шаардлага,
- Хувийн тээврийн хэрэгслийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж шатахуун зарцуулсан 7.8 сая төгрөг/ СУГ/
- Албан хэрэгцээнд автомашин ашигласан 1.1 /Булган сумын ЗДТГ/
- Автотээврийн хэрэгслийн тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй гэсэн 7 зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг тооцсон.

А.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуульд цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2022, 2023, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2.1 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэн

- Хутаг-Өндөр сумын ЗДТГ 810.0,
- Орхон сумын ЗДТГ биеийн тамирын өмсгөл 375.0,
- Бугат сумын ЗДТГ үйлчилгээний албан хаагчдад нормын хувцас 600.0 мянган төгрөгийг
- Байгаль хамгаалах сангаас 0.2 сая төгрөгийн хантааз худалдан авсан /аймгийн БХС/

А.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд гадаад томилолтын зардалд 2022 онд 56,382.0 мянган төгрөг, 2023 онд 113,463.1, мянган төгрөгийг зарцуулжээ. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хязгаарлалт, зохицуулалттай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

А.1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1¹ дэх заалтыг дагуу аудитаар түүвэрт хамруулан шалгасан 4 орон нутгийн өмчит байгууллагаас удирдах болон бусад албан тушаалтны үндсэн цалинг тогтоосон байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд ТУЗ-ын тогтоолоор 4 байгууллага нь удирдах болон бусад албан тушаалтны үндсэн цалинг тус тус тогтоосон байна.

Дээрх 4 орон нутгийн өмчит байгууллагууд нь удирдах албан тушаалтны үндсэн цалинг 2024 онд 1.5-2.1 сая төгрөгөөр, албан хаагчдын цалинг 2023, 2024 онд 0.5-1.8 сая төгрөгөөр тус тус харилцан адилгүй тогтоосон байна.

Энэ нь ижил хөдөлмөрт тэгш цалин олгогдох боломж алдагдах, ажлын хариуцлага, бүтээмжид сөрөг үр дагавар үүсгэх, боловсон хүчний тогтвортой байдал алдагдах эрсдэлийг үүсгэсэн байна. Иймд ОНӨААТҮГ-ын удирдлага болон ажилчдын цалин хөлсний нийтлэг жишгийг үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан тогтоож өгөх шаардлагатай байна.

А.1.5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй гэж заасныг байгууллагууд хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үзэхэд 2023 онд 351.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 331.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж 20.1 сая төгрөгөөр, 2024 онд 246.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 158.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж 88.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Тодруулбал:

- 2023 онд Баян-Агт сумын ЗДТГ 20.1,
- 2024 онд Баяннуур ЗДТГ 47.6, Хялганат тосгоны Захирагчийн алба 40.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж хэмнэлт нь 2023 онд 1 албан хаагч, 2024 онд 2 байгууллагын 4 албан хаагч өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарахыг хойшлуулсан болон төрийн албан хаагчийн хүний нөөцийн дутагдалтай байгаагаас үргэлжлүүлэн ажиллаж буй зэргээс шалтгаалсан байна.

А.2 Сумын ЗДТГ-ууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн бусад арга хэмжээний хориглосон заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 20.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

¹ Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг ... орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

А.2.1 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хориглосон заалтуудыг зөрчсөн нийт 14 байгууллагын 35.7 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин бэлэг дурсгалын зүйл, хүнсний зардалд зарцуулсан зөрчил 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт. /Хангал сумын ЗДТГ/
- Засаг даргын нөөц хөрөнгөөс зочин төлөөлөгчдөд гарын бэлэг гардуулсан зөрчилд 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт /Хангал сумын Хялганат тосгоны ЗАА/
- Булган аймгийн Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын 100 жилийн ойд зориулан хандив өгсөн зөрчилд 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт /Бугат сумын ЗДТГ/
- Төсвөөс санхүүчдийн баярт зориулан бэлэг дурсгалын зүйлд 0.5 сая төгрөгийг зарцуулсан /Бугат сумын ЗДТГ/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин төсвөөс 2 мөнгөн аяга авахад 1.1 сая төгрөгийг зарцуулсан /Бугат сумын ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл 0.4 сая төгрөгийг зарцуулсан /Бугат сумын ИТХ/
- Засаг даргын нөөц хөрөнгөөс зочин төлөөлөгчдөд 2.8 сая төгрөгөөр гарын бэлэг бэлтгэсэн /Орхон сумын ЗДТГ /
- Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумын 100 жилийн ойд 2.5 сая төгрөгийн хандив өгсөн /Сэлэнгэ сум ОНХС/
- Сумын ЗД-ын нөөц хөрөнгөөс сумын алдартнуудад 0.4 сая төгрөгийн бэлэг олгосон. /Могод сумын ЗДТГ/
- Жилийн эцэст байгууллагын ажилчдад “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг зөрчиж согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйлд төсвийн хөрөнгийг зарцуулсан санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Хангал сумын ЗДТГ/
- Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлд 0.5 сая төгрөгийг зарцуулсан

Хэрэгцээ, шаардлагагүйгээр болон их хэмжээгээр бараа материал нөөцлөхийг хориглосон заалтыг зөрчсөн “Булган Мээж” ОНӨХХК нь “Цемент шохой” ТӨХК-аас 1000 шуудай буюу 50 тн цемент авч жилийн эцсийн байдлаар бараа материалын дансанд 559 шуудай 27.9 тн хэрэгцээ шаардлага нь тодорхойгүй материал нөөцөлсөн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуулийн 15.1.3-д хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох хязгаарлалтын хүрээнд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн хуулийн 15.1.3-д заасныг зөрчин шагнал, дурсгалын зүйлд 0.2 сая төгрөгийг зарцуулсан /Хангал сумын ИТХ/

- Тайлангийн хугацаанд цалингийн зардлаас тэргүүний ажилтан шалгаруулан шагнал урамшуулал олгосон байна.

Дээрх зөрчлийн дийлэнх хувийг бэлэг дурсгалын зүйл худалдан авах, хандив өгөх зэрэг зөрчлүүд эзэлж байгаа нь Төрийн хэмнэлтийн бусад арга хэмжээнд заасан хязгаарлалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Б. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН 21 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 1701.8 САЯ ТӨГРӨГИЙН АЖЛЫГ ЗУРАГ ТӨСӨВГҮЙ БАТАЛСАН БАЙНА.

Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц, гэрээний хугацаа гүйцэтгэлийн чанарт анхаарах шаардлагатай байна.

2022-2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар 2022 оны IX/16 тогтоолоор 3,553.8 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээ, 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн IX/01 тогтоолоор 72 төсөл арга хэмжээнд 10,060.3 сая төгрөгийг баталжээ.

Хүснэгт № 2 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд баталсан төсөл арга хэмжээний ангиллаар харуулбал: /мян.төг/

№	Төсөл арга хэмжээний ангилал	2022		2023	
		TAX тоо	TAX дүн	TAX тоо	TAX дүн
1	Барилга, байгууламж	3	180.00	19	4,293.2
2	Их засвар	16	2,403.8	25	3,874.6
3	Тоног төхөөрөмж	14	970.0	28	1,892.6
Нийт дүн		33.00	3,553.8	72	10,060.4

Дээрх онуудад баталсан хөрөнгө оруулалтаас техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээг 2022 оны төсөвт 16 төсөл арга хэмжээнд 1001.8, 2023 онд 5 төсөл арга хэмжээнд 700.0 сая төгрөг тусган баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4²-д, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3-д “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.” гэсэн заалттай нийцээгүй байна. /Хавсралт № 1/

Тус газрын хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2023 оны хөрөнгө оруулалтаар ажлын гүйцэтгэл хангалтгүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйтэй холбоотой 3152.3 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

² 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

- **Сайхан сумын соёлын төвийн их засварын ажлыг** “Алист констракшн” ХХК 99.9 сая төгрөгөөр сумын Засаг даргатай гэрээ байгуулж хийсэн ч засварын төсөвт тусгагдсан хяналтын камер хийх 4.3 сая төгрөгийн ажлын төсвөөр цахилгааны гол шугам солих, разетка, унтраалга, автоматын хайрцаг иж бүрнээр сольсон гэх боловч төсөвт өртгийг тооцоогүй.
- **Хутаг-Өндөр сумын соёлын төвийн их засварын ажлыг** “Хурмастын хүлэг” ХХК 214.6 сая төгрөгөөр гэрээ байгуулж хийсэн засварын ажлаас тайзны шалны 1.8 сая төгрөгийн ажлыг хийгдээгүй байна. Энэхүү ажлыг өмнөх жил сумын төсвөөр хийлгээсэн байсан гэх шалтгаанаар ашиглагчийн хүсэлтээр төсөвт тусгагдсан 2 ширхэг төмөр хаалга буюу 1.6 сая төгрөгийн ажлыг 5.0 сая төгрөгийн хаалга суулгасан гэх тайлбарыг захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас ирүүлсэн.
- **Сэлэнгэ сумын Соёлын төвийн барилгын засварын ажлыг** “Хурмастын хүлэг” ХХК 350.0 сая төгрөгийн гэрээ байгуулж засварын ажлыг хийсэн, үүнээс дотор заслын ажилд 340 м.кв тааз, 165 ш нүдэн гэрэл суулгах ажил хийгдэхээр байсан, энэ ажил нь зураг төсвийн дагуу хийгдээгүй, өөрчлөн өөр ажил хийсэн ч төсвийн тооцоо, зураг төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.
- **Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байрны барилгын их засвар:** Гүйцэтгэгч “Хөх сэрхийн мандал” ХХК 496.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан, засвар хийсэн гал тогооны өрөөний хана, таазны будаг хуурсан, дээврийн карниз, усны хаялаг шинээр хийгээгүй, салхивчийн систем ажиллаагүй байна.
- **Хангал сумын сургуулийн хичээлийн байрны их засварын ажлыг** “Эрдэнэс эко үүр” ХХК 192.4 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгээсэн. Улсын комиссын хурлын тэмдэглэлд цонхны амлагааг гүйцээж хийх үүрэг даалгавар өгсөн ч биелүүлээгүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц, хэрэгжилт удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх улмаар төсөл, арга хэмжээг гэрээт хугацаанд ашиглалтад оруулах боломжгүй байдалд хүрэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Аймаг, сумдын ОНХО-ын төлөвлөгөөнд хэдийгээр тодорхой хэмжээний иргэдийн эрх ашигт нийцэж санал авсан боловч тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих бус төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр, фасадны засварын 4 төсөл, арга хэмжээг 282.0 сая төгрөгөөр тусгаж, хэрэгжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3³: 13.3.2⁴-д заасныг зөрчиж байна.

³ Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

⁴ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

2022 онд олгохоор баталсан санхүүжилтийн үлдэгдэл болох 670.1 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагааны хүрээнд бий болсон хэмнэлтээс 72.5, хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээний 186.1 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд, дутуу болон он дамнан хэрэгжиж байгаа 4 төсөл, арга хэмжээний 440.9 санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх ажлыг хийж хэвшсэн боловч хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө хууль, журмын шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 3 Орон нутгийн хөгжлийн сангаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ

Д/д	Аймаг, сумдын нэрс	Батлагдсан төсөл, арга хэмжээ		Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ		ТЭЗҮ, зураг, төсөвгүй		Нийт дүн	
		тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг
1	Булган	12	407.4			1	35	1	35
2	Орхон	25	813.7	6	34.5			6	34.5
3	Сэлэнгэ	48	420.4	30	193.5	48	420.4	78	613.9
4	Хутаг-Өндөр	28	801.9	5	52.1	10	120.7	15	172.8
	Нийт дүн	113	2443.4	41	280.1	59	576.1	100	856.2

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 16.8 хувь буюу 856.2 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Б. 2 Цахим худалдан авах ажиллагааг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

Төрийн байгууллага буюу захиалагчид тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсвэл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах талаар хуулиар зохицуулсан.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авах бараа үйлчилгээний жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнээс 2022 онд аймгийн Эрүүл мэндийн газар 41 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг 139.6, аймгийн нэгдсэн эмнэлэг 57 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгслийг 131.7 сая төгрөгөөр ерөнхий гэрээний аргаар худалдан авсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас 2023, 2024 онд цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авсан эсэхийг сумын ЗДТГ-ууд, аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас түүвэрлэн үзэхэд аймгийн ЗДТГ 43.8 сая төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдаж авсан, бусад байгууллагууд худалдан авалт хийгээгүй гэсэн судалгааг ирүүлсэн, тодруулахад цахим дэлгүүрийн бараа бүтээгдэхүүний сонголт цөөн, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, захиалагч байгууллагын тавьсан шаардлага нийцээгүй учраас худалдан авалт хийгээгүй гэсэн тайлбарыг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2022, 2023 онд цахим худалдан авалттай холбоотой 405.1 сая төгрөгийн 6 албан шаардлага, 10,639.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өгчээ.

Цаашид цахим дэлгүүрийн барааны нэр төрөл болон бэлтгэн нийлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх, мөн цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүнийг хэрхэн захиалах, ямар давуу талууд байгаа талаар сумдад сургалт, мэдээлэл өгөх шаардлагатай байна.

В.1 Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналтаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч хуулийн хэрэгжилт, үр дүн нэмэгдэхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу 2023 онд 96.9 сая төгрөгийн 32 зөрчил, 2024 онд 389.3 сая төгрөгийн 18 зөрчил илрүүлж, өмнөх оноос зөрчлийн тоо 56.2 хувиар буурсан байна.

Хүснэгт № 4. Төрийн хэмнэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн хяналт

мянган төгрөгөөр

№	Зөрчлийн ангилал	Шийдлийн нэгтгэл				Үүнээс											
						Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж			
		2023 он		2024 он		2023 он		2024 он		2023 он		2024 он		2023 он		2024 он	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тээврийн хэрэгсэл	4	983	-	-	-	-	-	-	2	982.5	-	-	2	-	-	-
2	Дүрэмт хувцас	1	3,750	3	1,785	-	-	3	1,785.0	1	3,750.0	-	-	-	-	-	-
3	Цалин хөлс, нэмэгдэл	1	535	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	534.8	-	-
4	Бусад хангамж	3	1,185	4	7,688	3	1,185.0	4	7,688.3	-	-	-	-	-	-	-	-
5	Цахим худалдан авалт	6	43,421	3	372,365	-	-	-	-	3	32,781.9	3	372,365.0	3	10,639.4	-	-
6	Хэмнэлтийн бусад арга хэмжээ	16	42,042	7	7,557	12	8,411.3	3	3,230.0	2	12,975.0	-	-	2	20,656.1	4	4,326.7
7	Тайлагналт, ил тод байдал	1	5,076	1	-	-	-	-	-	1	5,075.9	1	-	-	-	-	-
	ДҮН	32	96,991.9	18	389,395	15	9,596.3	10	12,703.3	9	55,565.3	4	372,365.0	8	31,830.3	4	4,326.7

Мэдээллийн эх сурвалж: 2023-2024, 2024-2025 онуудын санхүүгийн тайлангийн аудит

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Булган аймгийн Засаг даргын “Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслийн ашиглалтын тухай” 2022 оны А/380 дугаар захирамжаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, автомашины ашиглахыг хориглох, ашиглалтын байдалд хяналт тавих чиглэлийг хүргүүлсэн байна.

Гэвч дээрх өгөгдсөн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээг нэгтгэн дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд орон нутагт ТЕЗ, салбар байгууллага хяналт тавих, үр ашгийг тооцох, биелэлтийг хангуулах чиглэлээр эрх зүйн орчин бүрдээгүй байна.

В.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, хэмнэлт, үр дүн тооцоогүй, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын ажил хангалтгүй байна.

Төрийн хэмнэлтийн хууль нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зорилготой.

Аймгийн ТЕЗ-ийн 2022-2024 оны төсөв жил бүр 18,864.0-25,782.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Үүнээс урсгал зардлыг бүлгийн дүнгээр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 5 ТЕЗ-ийн сүүлийн 3 жилийн урсгал зардал

№	Зардал бүлгээр	2022		2023		2024	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Урсгал зардал	50,559.4	43,507.7	73,711.9	65,110.6	93,345.3	82,435.4
1	Цалин хөлс	8,833.6	8,487.7	13,541.4	12,942.4	19,632.1	19,032.2

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн

2	АО төлөх НДШ	1,105.2	1,047.2	1,704.2	1,590.6	2,462.4	2,375.2
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,538.6	10,347.0	11,947.6	11,451.4	14,375.5	13,905.0
4	Хангамж, бараа материалын зардал	725.0	710.1	951.8	913.5	1,022.7	990.0
5	Норматив зардал	210.0	208.7	239.7	237.1	262.7	260.3
6	Эд хогшил, урсгал засвар	1,595.9	1,541.6	2,157.2	2,045.3	2,014.8	1,960.0
7	Томилолт	344.2	285.5	477.6	377.7	571.0	517.5
8	Бусдаар гүйцэтгүүлсэн зардал	810.7	774.3	2,509.9	2,305.4	3,461.0	3,183.7
9	Бараа үйлчилгээний бусад	9,288.9	7,798.7	12,684.8	11,193.6	16,698.7	14,088.8
10	Урсгал шилжүүлэг	997.4	933.5	1,502.1	1,245.6	2,672.6	2,364.4
11	Хөрөнгийн зардал	16,110.0	11,373.5	25,995.6	20,808.2	30,171.9	23,758.4

Булган аймгийн 2024 оны төсвийн зарлагыг 99,307.9 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 86,411.4 сая төгрөг буюу төсвийн 87.0 хувийг зарцуулж, 12,866.6 сая төгрөгийн хэмнэгдсэн байна. Хэмнэлтийн 65.8 хувийг хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх зээл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд автомашины хэрэглээг хязгаарлах, татан төвлөрүүлэх арга хэмжээг аваагүй, тээвэр шатахууны үнэ ханш сүүлийн жилүүдэд тогтвортой байсан ч зардал буураагүй жил бүр 34.2-125.5 сая төгрөгөөр буюу 13,900-51,224 литрээр хэрэглээ өссөн байна.

Албан томилолтын зардлын батлагдсан төсвөөс 53.5-99.9 сая төгрөгөөр хэмнэгдэж байгаа хэдий ч жил бүр зардал 92.2-139.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт№6 Төрийн хэмнэлтийн тухай хуульд тусгасан урсгал зардлуудын төлөвлөгөө гүйцэтгэл

Зардлын үзүүлэлт	2022			2023			2024		
	Төлөв	Гүйц	Хэмнэлт	Төлөв	Гүйц	Хэмнэлт	Төлөв	Гүйц	Хэмнэлт
Бичиг хэрэг	92.3	90.5	1.8	118.4	115.7	2.7	144.5	142.8	1.7
Тээвэр шатахуун	424	422.6	1.4	559.7	548.1	11.6	588.3	582.6	5.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,538.6	10,347.0	191.6	11,947.6	11,451.4	496.1	14,375.5	13,905.0	470.4
Албан томилолт	344.2	285.5	58.7	477.6	377.7	99.9	571.0	517.5	53.5

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 31,035.9 сая төгрөгийн 423 алдаа, зөрчил илрүүлснээс санхүүгийн 21,595.0 сая төгрөгийн 384, нийцлийн 9,440.9 сая төгрөгийн 39 алдаа зөрчил тус тус илэрчээ.

Үүнээс 10,759.2 сая төгрөгийн 86 алдааг залруулж, 170.8 сая төгрөгийн зөрчилд 106 төлбөрийн акт, 12,154.4 сая төгрөгийн 86 зөрчилд албан шаардлага, 1,689.2 сая төгрөгийн зөрчилд 5 хариуцлага тооцох албан шаардлага, 6,262.3 сая төгрөгийн зөрчилд 140 зөвлөмжийг тус тус хүргүүлж, алдаа зөрчил тодорхой хэмжээнд

буурахгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Үр ашигтай байх”, “Сахилга баттай байх”, ил тод байх, хариуцлагатай байх, “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” зарчмуудыг баримтлан ажиллаагүй байна.

Иймд төсвийн болон орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмуудыг мөрдөж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь батлагдаж гарснаас хойш 6-н удаагийн нэмэлт өөрчлөлт ороход хуулийн үйлчлэх хүрээ, хязгаарлалтуудыг нэмэгдүүлсэн, хариуцлагыг сулруулсан, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; заалтыг хассан өөрчлөлтүүд хийж байгаа нь тус хуулийн зорилго үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон зохицуулалтууд суларч байна.

В.3 Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

В.3.1 Шилэн дансны тухай хуульд зааснаар төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нь зорилтот түвшин, түүний гүйцэтгэл, таван сая төгрөгөөс дээш худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн төсөл, тендерийн мэдээлэл зэргийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын санхүүгийн тайланд хийгдсэн 2023, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Тодруулбал:

- 2023 онд 23 зөрчил илэрснээс 3 байгууллагын 5 албан хаагчид хариуцлага тооцох болон 6 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмж өгөгдсөн,
- 2024 онд 19 зөрчил илэрснээс 9 байгууллагад албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт № 7 Шилэн дансанд байршуулах мэдээллийг мэдээлсэн байдал:

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс:		
			Хариуцлага тооцох	Албан шаардлага	Зөвлөмж
1	Төсвийн байгууллага /52/	26	3	11	12
2	Орон нутгийн өмчит байгууллага /12/	16	-	4	12
	Нийт дүн	42	3	15	24

Дээрхээс харахад 2024 оны зөрчил өмнөх оноос буурсан хэдий ч орон нутгийн өмчит байгууллагуудын алдаа зөрчил нь нийт зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

Үүнээс дүгнэхэд зарим байгууллагууд нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулах, хугацаа хоцроох зэргээр холбогдох ажилтны хариуцлагагүй байдал, удирдлагын зүгээс тавих хяналт сул байгаагаас шалтгаалан зөрчил давтагдсан харагдаж байна.

Иймд орон нутгийн өмчит байгууллагууд нь шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, бүрэн мэдээлж байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн нийт төсөвт байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 62.3 хувь, ТЭЗ-ийн харьяа байгууллагын 39.6 хувь нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хориглосон заалтуудыг хэрэгжүүлж, ажиллаагүйгээр нийт 17.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.
- Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой төрийн байгууллагууд худалдан авалт хийгээгүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу хяналтыг хэрэгжүүлж байгаа ч хяналтын тогтолцоо бүрдээгүй, ТЭЗ болон харьяа байгууллагууд үр дүнтэй зохион байгуулж, ажиллаагүй байна.
- Аймаг, сумын ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд ТЭЗҮ-гүй хөрөнгө оруулалтыг тусгасаар байна.
- Орон нутгийн өмчит байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Ж.Ганболдод

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй хөрөнгө оруулалтыг батлахгүй байх, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очирт:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авах, гарч байгаа алдаа зөрчлийг бууруулах талаар тодорхой чиглэлүүдийг харьяа байгууллагуудад өгөх.

Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Баярцэнгэлд:

- Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх талаарх мэдээлэл, сургалтыг төсөвт байгууллагуудад явуулж, худалдан авалтыг нэмэгдүүлэх, цахим худалдан авалтын талаарх тоо мэдээлэл гаргаж, хяналт тавьж байх.

Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулгад

- Төсөвт байгууллага, төрийн өмчит газруудад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн бүртгэлийг АТҮТ-ын Булган салбартай тулгалт хийж, акталсан болон ашиглахгүй байгаа тээврийн хэрэгслийг хасалт хийх, шилжүүлэх ажлын зохион байгуулах.

-oOo-